



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/39

Жаргалант

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Улсын Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.5, 18.2.12, 18.2.13, 18.2.14, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”-ын 1.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлдөө цас багатай, хуримтлагдсан хагд өвс ихтэй ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн цаг агаарын хуурайшилтай байгааг харгалзан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ний өдрийг хүртэлх хугацаанд сумын нутаг дэвсгэрт ойгоос мод бэлтгэх, тээвэрлэх, иргэдийн аялал зугаалга, амралт сувилалын зорилгоор ой хээрийн бүсэд зорчих, үйл ажиллагаа явуулах, ан амьтан агнах, загас барих, ойн дагалт баялаг, байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүж бэлтгэх, ойн сангийн талбайд мал бэлчээх, ямарваа үйл ажиллагаа эрхлэхийг хориглосугай.

2.Орон нутгийн цаг агаарын нөхцөл байдлыг үндэслэн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг оновчтой зохион байгуулж иргэд, малчдын бүлэг, ойн болон иргэдийн оролцоотой байгаль хамгаалах сайн дурын нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулан баталгаа гаргуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

3.Ой хээрийн бүсэд түймрийн аюултай улиралд ил задгай гал түлэхгүй байх, ахуйн гал түүний цог нурам, асаасан тамхи шүдэнзний галыг ил задгай хаяхгүй байх, яндангийн оч баригчгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган гал түймэр унтраах багаж хэрэгслийг бүрдүүлэн хөдөлгөөнд оролцож ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нийт иргэд, малчид тариаланчид, тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт анхааруулсугай.

232501093

Байгаль орлого
Хүснэгт
Огноог

Handwritten signature

2.

4.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулах, сэрэмжлүүлэх ухуулга, сурталчилгааг сайтар зохион байгуулж түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах зохион байгуулалтын арга хэмжээг урьдчилан төлөвлөж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баасансүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

